МЭДЭЭ · 2023 оны 7-р сарын 4

ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРГҮҮДЭД АЖЛЫН ХЭСГИЙН ПРОКУРОРУУД ХЯНАЛТ ТАВЬЖ БАЙНА



Бусдын эд хөрөнгийг шилжүүлэн авахаар хүч хэрэглэх, заналхийлэх гэмт хэргийг зохион байгуулалттай бүлэглэн үйлдэж, хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх зөрчигдөж байгаа талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр удаа дараа нийтлэгдэх болсон.

Улсын ерөнхий прокуророос хүний эрх, эрх чөлөө, өмчлөх эрхийг хамгаалах, гэмт үйлдлийг таслан зогсоох, зөрчигдсөн эрхийг сэргээх зорилгоор зохион байгуулалттай бүлэг этгээдийн үйлдсэн бусдын эд хөрөнгийг авахаар хүч хэрэглэсэн, заналхийлсэн гэмт хэргийг шалгаж, шийдвэрлэх 8 прокурорын бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулжээ.

Ажлын хэсэг нь мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргийг шалгаж шийдвэрлэхэд зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжүүлж байна. Тухайлбал, нийт 32 хүнийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татан, гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, дахин үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор 25 хүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1555